

# ДАРАА ТӨЛБӨРТ МОНГОЛДОО ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

## НЭГ. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

Энэхүү Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлд дараах нэр, томьёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

- 1.1.1 “**Бүртгэлийн хураамж**” гэж шинэ хэрэглэгчийн дугаарын нэг удаагийн, эргэн төлөгдөхгүй төлбөрийг;
- 1.1.2 “**Барьцаа төлбөр**” гэж Хэрэглэгч хэрэглээний төлбөр төлөх үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хэрэглэгчээс урьдчилан төвлөрүүлсэн хөрөнгийг;
- 1.1.3 “**Сарын суурь хураамж**” гэж Хэрэглэгч нь үйлчилгээ үзүүлэгчийн сүлжээ ашигласнаар сар бүр тогтмол төлөх төлбөрийг;
- 1.1.4 “**Багцын хэрэглээний эрх**” гэж Хэрэглэгчийн ашиглаж буй багцын сарын суурь хураамжид багтаж буй (яриа, мессэж, дата эрх) үйлчилгээний эрхийг;
- 1.1.5 “**Нэмэлт үйлчилгээ**” гэж хэрэглэгчийн ашиглаж байгаа яриа, мессэж, дата хэрэглээнээс бусад нэмэлтээр үзүүлж буй үйлчилгээг;
- 1.1.6 “**Үйлчилгээний төлбөр**” гэж Хэрэглэгчийн дугаарт бодогдсон тухайн сарын хэрэглээний төлбөр, сарын суурь хураамж, бусад холбогдох төлбөр, хөнгөлөлт болон НӨАТ зэргийн нийлбэр дүнг;
- 1.1.7 “**Үйлчилгээ хооронд шилжих**” гэж Хэрэглэгч дугаар солилгүйгээр ашиглаж буй багцаа өөрчлөхийг;
- 1.1.8 “**Дугаар хадгалах үйлчилгээ**” гэж Хэрэглэгч дугаараа ашиглахгүй тохиолдолд үйлчилгээний салбарт хандаж 12 сар хүртэлх хугацаанд бүрэн хаалгаж, хадгалуулах үйлчилгээг;
- 1.1.9 “**Дугаар түр хаах, нээх**” гэж Хэрэглэгч гар утас болон сим картаа үрэгдүүлсэн тохиолдолд өөрийн хүсэлтээр 1-14 хоног дугаарыг түр хаах, нээх үйлчилгээг;
- 1.1.10 “**Эзэмших эрх шилжүүлэх**” гэж Хэрэглэгч өөрийн нэр дээр эзэмшиж буй дугаарыг бусдад шилжүүлэх үйлчилгээг;
- 1.1.11 “**Сим карт сэргээх**” гэж Хэрэглэгч шинээр Сим карт худалдан авахыг;
- 1.1.12 “**Хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалт**” гэж Хэрэглэгчийн гарах яриа, мессэж хэрэглээ хийсэн дугаарын жагсаалт болон бодогдсон төлбөрийн мэдээллийг;
- 1.1.13 “**Үйлчилгээ зогсоох**” гэж орох гарах яриа, мессэж, дата үйлчилгээний эрхийг зогсоох;
- 1.1.14 “**Биллинг цикл**” гэж сарын эхний өдрөөс сарын сүүлийн өдөр дуусталх хугацааг;
- 1.1.15 “**МОНГОЛДОО ҮЙЛЧИЛГЭЭ**” гэж яриа болон дата эрхтэй дараа төлбөрт үйлчилгээг;
- 1.1.16 “**Зүй зохисгүй хэрэглээ**” гэж үйлчилгээ үзүүлэгчийн дугаар бүхий Сим картанд тусгай зориулалтын төхөөрөмж, программ хангамж холбож, зөвшөөрөлгүйгээр нэг дор их хэмжээний дуут сурталчилгаа/Voice broadcast/, дуудлага ашиглан сурталчилгаа түгээх/outbound call center/, мессэж сурталчилгаа /SMS broadcast/ явуулах, бооцоот тоглоом болон хууль бус, түсгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа сурталчилсан, түгээсэн, бусдыг доромжилсон, ялгаварлан гадуурхсан, хууль бус үйлдэл хийхийг уриалсан, дарамт үзүүлсэн, Үйлчилгээ үзүүлэгч болон бусад операторын сүлжээнд хор нөлөө үзүүлж ашигласан, болон үүгээр хязгаарлагдахгүй хууль, дүрэм, гэрээнд хориглосон үйлдэл гаргасан, ашигласан.
- 1.1.17 “**Олон Улсын ярианы үйлчилгээ**” гэж олон улсын ярианы үйлчилгээний барьцаа байршуулсан хэрэглэгч 002 гарцыг ашиглан гадаад улс руу дуудлага хийх, мессэж илгээх үйлчилгээг;
- 1.1.18 “**Олон Улсын Роуминг үйлчилгээ**” гэж гадаад улсад зорчихдоо өөрийн дугаараа ашиглан зөвхөн үйлчилгээ үзүүлэгчтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан гадаадын операторуудын сүлжээг ашиглах үйлчилгээг;
- 1.1.19 “**Онлайн яриа (Facetime) болон мессеж (iMessage, Mi Message) үйлчилгээ**” гэж зарим үйлдлийн системд ажилладаг, хэрэглэгч өөрийн дугаарыг ашиглан зурвас, зураг, видео илгээх, мөн аудио болон видео дуудлага хийх аппликейшний үйлчилгээг;
- 1.1.20 “**Тоон гарын үсэг**” гэж цахим баримт бичгийг хуурамчаар үйлдэх, өөрчлөхөөс хамгаалах зорилгоор тоон гарын үсгийн хувийн түлхүүр ашиглан мэдээллийг криптограф хувиргалтад оруулж үүсгэсэн, уг баримт бичгийн бүрдэл болох цахим гарын үсгийн төрлийг;
- 1.1.21 “**Идэвхтэй төлөв**” гэж төлбөрийн улмаас, хэрэглэгчийн хүсэлтээр хаагдсанаас бусад төлвийг хэлэх;
- 1.1.22 “**4G LTE үйлчилгээ**” гэж Үүрэн холбооны 4-дэгч үеийн LTE (Long Term Evolution) технологи ашигласан хөдөлгөөнт, өндөр хурдны Интернетийн үйлчилгээг;
- 1.1.23 “**Задгай хэрэглээ**” гэж багцад дагалдах яриа, мессеж, дата эрхийн хязгаараас давсан нэмэлт хэрэглээг;

- 1.1.24 “**eSIM**” гэж үйлчилгээ үзүүлэгчээс өгсөн QR кодыг уншуулж өөрийн гар утас, төхөөрөмжинд биет бус Сим картаар дугаар суулган ашиглах үйлчилгээг;
- 1.1.25 “**ДАН систем**” гэж Танилт нэвтрэлтийн нэгдсэн систем буюу иргэнийг цахим орчинд таньж баталгаажуулан ХҮР системээс улсын бүртгэл дэх иргэний мэдээллийг үйлчилгээ үзүүлэгчийн мэдээллийн санд татан авах үйлчилгээг;
- 1.1.26 “**Мэдээллийн эзний зөвшөөрлийн хуудас**” гэж “Скайтел” ХХК нь Хэрэглэгчид өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэхдээ Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 6.1.1, 6.1.2, 6.1.4, 8.1, 8.2, 8.3, 8.4, 9.2.1, 18.1-т Улсын бүртгэлийн хуулийн 12.4-т тус тус заасны дагуу мэдээллийн эзэнд танилцуулж авсан зөвшөөрлийн нөхцөлийг;
- 1.1.27 “**Тан код**” гэж Хэрэглэгч үйлчилгээ авах үед нэг удаа ашиглах оронтой тоон илэрхийлэл бүхий баталгаажуулах кодыг;
- 1.1.28 “**Олон улсын дата eSIM**” гэж үйлчилгээ үзүүлэгчээс өгсөн QR кодыг уншуулан хэрэглэгч өөрийн гар утас, төхөөрөмжид биет бус Сим карт суулган, гадаад улс орнуудад дата интернэт ашиглах боломжийг олгох үйлчилгээг;
- 1.1.29 “**Оргил цаг**” гэж утасны дуудлага, интернет хэрэглээ, мессеж болон мэдээлэл солилцоо хамгийн их ачаалалтай, идэвхтэй явагддаг хугацааг;

## ХОЁР. ҮЙЛЧИЛГЭЭНИЙ НӨХЦӨЛ

### **2.1 Шинэ хэрэглэгч болох**

- 2.1.1 Дараах тохиолдолд шинэ хэрэглэгч болох боломжтой. Үүнд:
  - 2.1.1.1 Үйлчилгээний салбарт хандан өөрийн иргэний үнэмлэх, тоон гарын үсэг болон ДАН системийн мэдээллээ өгөх;
  - 2.1.1.2 Цахим орчинд ДАН системийн мэдээллээ өгөх;

### **2.2 Бүртгэлийн хураамж**

- 2.2.1 Шинэ хэрэглэгч нь энгийн, азын, алтан, үнэ цэнтэй дугаар худалдан авах бол Хавсралт №1-ийн 1.1 болон Хавсралт №1-ийн 1.1.1-д заасан бүртгэлийн хураамжийг төлнө.
- 2.2.2 Хавсралт №1-ийн 1.1.1-д заасан үнэ цэнтэй дугаарыг 12 (арван хоёр) сарын хугацаанд дугаараа тасралтгүй ашиглах нөхцөлөөр МОНГОЛДОО 55 болон түүнээс дээш багцаар бүртгэлийн хураамж 0 төгрөгөөр авах боломжтой.
- 2.2.3 Гэрээний 2.2.2-д заасан нөхцөлийн дагуу дугаар авсан тохиолдолд 12 (арван хоёр) сарын хугацаанд МОНГОЛДОО 40 багц руу бууруулах боломжгүй. Мөн эзэмших эрх шилжүүлэх үйлчилгээ авах тохиолдолд Гэрээний 2.2.2-д заасан хөнгөлөлт цуцлагдах бөгөөд шилжүүлж буй хэрэглэгч нь тухайн дугаарын үндсэн бүртгэлийн хураамжийг бүтэн төлнө.
- 2.2.4 eSIM сонгосон хэрэглэгч Хавсралт №2-ын 2.4-т заасан бүртгэлийн хураамжийг нэмэлтээр төлнө.

### **2.3 Сарын суурь хураамж**

- 2.3.1 Хэрэглэгч тухайн сард хэрэглээ хийсэн бол ашиглаж буй багцын сарын суурь хураамж бүтэн тооцогдоно.
- 2.3.2 Сарын аль ч өдөр шинэ хэрэглэгч болсон тохиолдолд зөвхөн тухайн сарын суурь хураамжийг Хавсралт №1-ийн 1.2-т заасан нөхцөлийн дагуу нэхэмжлэх бөгөөд багцад дагалдах хэрэглээний эрхийг бүтэн олгоно.
- 2.3.3 Урьдчилсан төлбөрт үйлчилгээнээс дараа төлбөрт үйлчилгээ рүү сарын аль ч өдөр шилжсэн тохиолдолд сарын суурь хураамж бүтнээр тооцогдоно.
- 2.3.4 Сарын суурь хураамж нь дараах нөхцөлүүдэд бодогдохгүй. Үүнд:
  - 2.3.4.1 Хэрэглэгч дугаар хадгалах үйлчилгээ авсан бол;
  - 2.3.4.2 Гэрээнд заасны дагуу үйлчилгээ үзүүлэгчийн санаачлагаар хэрэглэгчийн үйлчилгээг бүхэлд нь зогсоосон бол;
- 2.3.5 Гар утас эзэлээр эсвэл хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан хэрэглэгчид 2.3.4.1, 2.3.4.2 заалтууд хамаарахгүй болно.
- 2.3.6 Хэрэглэгч сарын түрш хэрэглээ хийгээгүй буюу идэвхгүй төлөвт байгаа тохиолдолд тус төлөвт шилжсэнээс хойш 3 хүртэлх сарын хугацаанд хэрэглээ хийгээгүй сар бүр Хавсралт №1-ийн 1.3-т заасан суурь хураамж нэхэмжлэгдэнэ.

### **2.4 Багцын хэрэглээний эрх**

- 2.4.1 Багцын дата эрхийг Скайтелын 3G, 4G LTE болон 5G сүлжээнд ашиглах боломжтой ба дата эрх дууссаны дараах хэрэглээ нь Хавсралт №2-ын 2.2-т заасан задгай датаны тарифаар тооцогдоно.
- 2.4.2 Задгай датаны хэрэглээг гигабайт (GB)-н нэгжээр тооцох ба Хэрэглэгчийн дата хэрэглээнээс хамааран төлбөрийг тооцож, суурь хураамж дээр нэмэлтээр нэхэмжилнэ.
- 2.4.3 МОНГОЛДОО 55 болон түүнээс дээш багцтай хэрэглэгчид оргил цагийн ачааллын үеэр дата үйлчилгээг 3 (гурван) дахин өндөр хурдаар ашиглах боломжтой байна.

- 2.4.4 Багцын ярианы эрхийг Скайтелын сүлжээн дэх яриа болон харилцан холболт бүхий дотоодын сүлжээнд ашиглах боломжтой бөгөөд зүй зохисгүй хэрэглэхээс сэргийлж зохист хэрэглээний хэмжээтэй байна.
- 2.4.5 Багцын мессэж эрхийг Скайтелын сүлжээнд болон харилцан холболт бүхий дотоодын операторуудын сүлжээнд ашиглах боломжтой ба зүй зохисгүй хэрэглэхээс сэргийлж, 1 өдрийн хэрэглээг 150 мессэжээр хязгаарлана.
- 2.4.6 Тусгай дугаарын яриа, видео дуудлага, Олон Улсын яриа болон Олон Улсын Роуминг үйлчилгээний ярианы хэрэглээ нь багцын ярианы эрхэд хамаарахгүй.
- 2.4.7 Багцад дагалдах хэрэглээний эрхийг ашиглах нөхцөл. Үүнд:
- 2.4.7.1 Тухайн сардаа ашиглаж дуусаагүй ярианы эрхийн хэрэглээ дараагийн 1 сард шилжинэ.
- 2.4.7.2 Багц шилжсэн тохиолдолд өмнөх сардаа ашиглаж дуусаагүй ярианы эрхийн хэрэглээ дараагийн сард шилжихгүй.
- 2.4.7.3 Тухайн сардаа ашиглаж дуусаагүй дата эрхийн хэрэглээ дараагийн сард шилжихгүй.
- 2.4.8 МОНГОЛдоо 100 багцтай хэрэглэгч нь 12 /арван хоёр/ сарын турш дугаараа тасралтгүй ашиглах нөхцөлөөр багцад дагалдах эрхийн хүрээнд гар утас төхөөрөмж хөнгөлөлттэй үнээр худалдан авах боломжтой.
- 2.4.9 МОНГОЛдоо 100 багцтай хэрэглэгч нь 12 /арван хоёр/ сардаа 1/нэг/ удаа бэлэн төлөлтөөр үйлчилгээний салбараас гар утас, төхөөрөмж худалдан авахдаа 600,000 /зургаан зуун мянган/ төгрөгийн хөнгөлөлт эдэлнэ.
- 2.4.10 Хэрэглэгч 12 /арван хоёр/ сарын хугацаанд дараах үйлчилгээг авсан тохиолдолд 2.4.8-д заасан хөнгөлөлтийг үйлчилгээ үзүүлэгчид бүрэн төлнө. Үүнд:
- 2.4.10.1 Багц буурах;
- 2.4.10.2 Үйлчилгээ хооронд шилжих;
- 2.4.10.3 Эзэмших эрх шилжүүлэх;
- 2.4.10.4 Дугаар хадгалах үйлчилгээ;
- 2.4.10.5 Гэрээ цуцлах.

## 2.5 Үйлчилгээний хугацаа

- 2.5.1 Дараа төлбөрт үйлчилгээний гэрээг байгуулсан өдрөөс эхлэн үйлчилгээний хугацааг тооцно.
- 2.5.2 Дараа төлбөрт үйлчилгээний гэрээг цуцалсан өдрөөр үйлчилгээний хугацаа дуусгавар болно.

## 2.6 Сим карт сэргээх

- 2.6.1 Хэрэглэгч үйлчилгээний салбарт хандан 3000 төгрөг төлж энгийн 4G LTE сим картаа сэргээлгэнэ.
- 2.6.2 Хэрэглэгч ашиглаж буй төхөөрөмжөө сольж өөр төхөөрөмжид eSIM-ийг ашиглах бол үйлчилгээний салбар, онлайн суваг ашиглан 5000 төгрөг төлж шинэ QR код худалдан авна.
- 2.6.3 МОНГОЛдоо 55 ба түүнээс дээш багцтай хэрэглэгч нь багцад дагалдах эрхийн хүрээнд 3 /гурван/ сар тутамд 1 /нэг/ удаа eSIM-ийг үнэ төлбөргүй дараах үйлчилгээний сувгуудаар сэргээх боломжтой. Үүнд:
- 2.6.3.1 Skytel.mn;
- 2.6.3.2 Skytel аппликейшн.

## ГУРАВ. ЗАХИАЛГАТ ҮЙЛЧИЛГЭЭ

### 3.1 Багц хооронд шилжих

- 3.1.1 Багц хооронд шилжих гэдэг нь дугаараа солихгүйгээр багцын төрлөө өөрчлөхийг хэлэх ба гар утас зээлээр эсхүл хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан хэрэглэгч багцаа бууруулах боломжгүй.
- 3.1.2 Багц хооронд шилжих үйлчилгээний хүсэлтийг сарын аль ч өдөр хүлээн авах бөгөөд үйлчилгээ нь зөвхөн дараа сарын 01-ний өдөр, идэвхтэй төлөвтэй дугаарт идэвхэжнэ.
- 3.1.3 Хэрэглэгч нь 6 /зургаан/ сард 1 /нэг/ удаа шатлан буурах зарчмаар багц буурах боломжтой ба багц ахих тохиолдолд өөрийн хүссэн багц руу сар харгалзахгүйгээр шилжих боломжтой.

### 3.2 Үйлчилгээ хооронд шилжих

- 3.2.1 Урьдчилсан төлбөрт үйлчилгээнээс Дараа төлбөрт үйлчилгээ рүү шилжихэд Дараа төлбөрт МОНГОЛдоо үйлчилгээний гэрээ байгуулна.
- 3.2.2 Хэрэглэгч урьдчилсан төлбөрт үйлчилгээнээс дараа төлбөрт үйлчилгээ рүү шилжихэд урьдчилсан төлбөрт нөхцөл дээр ашиглаж байсан үйлчилгээний хугацаа болон нэгж устана.
- 3.2.3 Урьдчилсан төлбөрт үйлчилгээнээс Дараа төлбөрт үйлчилгээ рүү шилжсэн хэрэглэгч дугаараа 3 сарын турш тасралтгүй идэвхтэй ашигласан тохиолдолд буцаад Урьдчилсан төлбөрт үйлчилгээ рүү шилжих боломжтой байх ба шилжих үед төлбөрийн үлдэгдэлгүй байна.
- 3.2.4 Хэрэглэгч Дараа төлбөрт үйлчилгээнээс Урьдчилсан төлбөрт үйлчилгээ рүү шилжих үед үйлчилгээний хугацаа тухайн өдрөөр, дансандаа 0 төгрөгний нэгжтэй байна.

### 3.3 Дугаар хадгалах үйлчилгээ

- 3.3.1 Дугаар хадгалах үйлчилгээ гэж хэрэглэгчийн хүсэлтийн дагуу дугаарын үйлчилгээний эрхийг төлбөртэй нөхцөлөөр 1-12 сар хүртэлх хугацаанд хааж, дугаарыг хадгалахыг хэлнэ.

- 3.3.2 Хэрэглэгч нь 3 ба түүнээс дээш сар дугаараа ашигласан, мөн өмнөх сарын төлбөр тооцоог бүрэн барагдуулсан тохиолдолд дугаар хадгалах үйлчилгээг авах боломжтой болно.
- 3.3.3 Хэрэглэгч нь дугаар ашиглаж байх хугацаанд төлбөр төлөхгүйгээр зөвхөн 1 удаа 1-4 хүртэлх сарын хугацаагаар дугаар хадгалах үйлчилгээг авах боломжтой.
- 3.3.4 Бусад тохиолдолд сард 10,000 /арван мянга/ төгрөгөөр 1-12 сар хүртэлх хугацаанд дугаар хадгалах үйлчилгээг авах ба үйлчилгээний төлбөрийг урьдчилан төлнө.
- 3.3.5 Дугаар хадгалуулах хүсэлт гаргасан сарын үйлчилгээний суурь хураамжийг бүтэн нэхэмжлэн суурь хураамжид дагалдах эрхийг бүтэн олгоно. Дугаар хадгалах үйлчилгээ авах хүсэлт гаргасан тухайн сарыг хадгалах хугацаанд оруулж тооцохгүй.
- 3.3.6 Хэрэглэгч гар утас зээлээр эсхүл хөнгөлөлттэй нөхцөлөөр авсан, мөн багц шилжүүлэх захиалга өгсөн бол дугаараа хадгалуулах боломжгүй байна.
- 3.3.7 Дугаар хадгалах хугацаа дуусахад үйлчилгээний эрх автоматаар нээгдэнэ. Үйлчилгээний эрх нээгдсэнээс хойш хэрэглэгч төлбөрийн үлдэгдэлтэй байж, төлбөр төлөх хугацаа хэтэрсэн бол үйлчилгээний эрх хаагдсан төлөвт шилжинэ.
- 3.3.8 Хэрвээ төлбөрийн үлдэгдэлгүй бол хэрэглээ хийгээгүй сар бүрд Үйлчилгээний нөхцөлийн 2.3.6-т заасан төлбөрийг нэхэмжилнэ.
- 3.3.9 Хэрэглэгч дугаар хадгалуулах үйлчилгээг дараах салбар болон сувгуудаас авах боломжтой. Үүнд:
- 3.3.9.1 Үйлчилгээний салбарт өөрийн биеэр цахим үнэмлэхний хамт;
- 3.3.9.2 Skytel.mn болон Skytel апплекейшн;

## 3.4 Дугаар түр хаах, нээх

- 3.4.1 Хэрэглэгч гар утас болон сим картаа алдсан, үрэгдүүлсэн тохиолдолд доорх сувгуудыг ашиглан гарах болон орох дуудлага, мессежийг 1-14 хоног түр хаах болон нээх боломжтой. Үйлчилгээ авах сувгууд:
- 3.4.1.1 Үйлчилгээний салбар;
- 3.4.1.2 Skytel.mn болон Skytel апп;
- 3.4.1.3 Лавлагаа мэдээллийн төв;
- 3.4.1.4 Киоск төхөөрөмж;
- 3.4.1.5 Чат бот;
- 3.4.2 Сарын дундуур үйлчилгээ нээлгэх хүсэлт гаргаж байгаа тохиолдолд үйлчилгээний суурь хураамж бүтнээр бодогдож үйлчилгээний эрхийг бүтэн олгоно.

## ДӨРӨВ. НЭМЭЛТ ҮЙЛЧИЛГЭЭ

### 4.1 Нэмэлт үйлчилгээ

- 4.1.1 Нэмэлт үйлчилгээний сарын суурь хураамж нь дараа төлбөрт үйлчилгээний багцын суурь хураамж дээр нэмэгдэнэ.
- 4.1.2 Нэмэлт үйлчилгээг сарын аль ч өдөр идэвхжүүлсэн үйлчилгээний төлбөр бүтэн тооцогдоно.
- 4.1.3 Хэрэглэгч нэмэлт үйлчилгээг зааврын дагуу цуцлах хүртэл биллинг циклээр буюу сар бүр ашиглах боломжтой байна.

### 4.2 Нэмэлт дата багц

- 4.2.1 Нэмэлт дата багцын үнэ тариф нь үйлчилгээ үзүүлэгчийн тогтоосон нөхцөлөөр зохицуулагдах ба 3G, 4G LTE болон 5G сүлжээнд ашиглах боломжтой байна.
- 4.2.2 Нэмэлт дата багцыг сарын аль ч өдөр идэвхжүүлсэн багцын төлбөр бүтэн тооцогдох ба тухайн сарыг дуустал ашиглах хугацаатай байх бөгөөд багцаас хэтэрсэн хэрэглээ нь Хавсралт № 2-ын 2.2-т заасан задгай тарифаар тооцогдоно.
- 4.2.3 Сар бүр автоматаар сунгагдах дата багц идэвхжүүлсэн тохиолдолд сар бүрийн үйлчилгээний суурь хураамж дээр дата багцын үнэ нэмж нэхэмжлэгдэх бөгөөд хэрэглэгч өөрөө мессэжээр цуцлах хүртэл дата багц сар бүр автоматаар сунгагдана.
- 4.2.4 123 дугаарт Data гэж илгээн дата багцын хэрэглээгээ шалгана.

### 4.3 Нэмэлт үйлчилгээ, дата багцыг идэвхжүүлэх, цуцлах

- 4.3.1 Нэмэлт үйлчилгээ болон дата багцыг доорх сувгуудыг ашиглан хэрэглэгч идэвхжүүлэх болон цуцлах боломжтой. Үүнд:
- 4.3.1.1 Тусгай дугаарт түлхүүр үгийг илгээн мессежээр;
- 4.3.1.2 \*123# дугаарт залгах;
- 4.3.1.3 Skytel.mn болон Skytel апп;
- 4.3.1.4 Киоск төхөөрөмж;
- 4.3.1.5 Чат бот;

### 4.4 Онлайн яриа болон мессеж илгээх

- 4.4.1 Онлайн яриа болон мессеж үйлчилгээг iPhone, Xiaomi гар утастай хэрэглэгч буюу iOS, HyperOS үйлдлийн системтэй утас болон төхөөрөмжний тохиргоон дээр iMessage, Mi message болон Facetime үйлчилгээг идэвхжүүлснээр энэхүү Үйлчилгээний нөхцөлийн Хавсралт №2-ын 2.4-т заасан төлбөр хэрэглэгчийн дугаарын тухайн сарын төлбөр дээр бодогдож зурвас, зураг, видео илгээх, аудио болон видео дуудлагыг хийх боломжтой болно.
- 4.4.2 Үйлчилгээ идэвхтэй хэрэглэгч дугаар болон утсан дээрээ дараах үйлчилгээг авсан, тохиргоо хийсэн бол Онлайн яриа болон мессеж илгээх үйлчилгээ

цуцлагдах тул дахин утас болон төхөөрөмжийн тохиргоон дээр идэвхжүүлж ашиглана. Үүнд:

- 4.4.2.1 Сим карт сэргээх;
- 4.4.2.2 Гар утас/төхөөрөмжөө солих;
- 4.4.2.3 iCloud/Mi cloud-аас бүртгэлээ гаргах;
- 4.4.2.4 Гар утас/төхөөрөмжийг форматлах;

#### 4.5 Олон улсын дата eSIM

4.5.1 МОНГОЛдоо 55-аас дээш багцтай хэрэглэгч нь багцад дагалдах эрхийн хүрээнд 6 /зураан/ сар тутамд 1 /нэг/ удаа 20,000 /хорин мянган/ төгрөгийн үнийн дүнтэй дата багцыг дараах үйлчилгээний сувгуудаар идэвхжүүлэх боломжтой. Үүнд:

- 4.5.1.1 Skytel.mn;
- 4.5.1.2 Skytel аппликейшн.

#### 4.6 Дата хуваалцах үйлчилгээ

4.6.1 Хэрэглэгч багцад дагалдах эрхийн хүрээнд тухайн сардаа Скайтелын сүлжээнд бүртгэлтэй нэг хэрэглэгчийн дугаарт SKAYTEL аппликейшнаар дараах үнийн дүнгээр шилжүүлэх боломжтой. Үүнд:

- 4.6.1.1 МОНГОЛдоо 30 болон МОНГОЛдоо 40 багцтай бол 10GB датаг 5000 /таван мянган/ төгрөгөөр шилжүүлэх;
- 4.6.1.2 МОНГОЛдоо 55 болон түүнээс дээш багцтай бол 20GB датаг үнэ төлбөргүй шилжүүлэх;
- 4.6.2 Хэрэглэгч нь багцад дагалдах дата эрхээсээ Скайтелын сүлжээн дэх урьдчилсан төлбөрт болон дараа төлбөрт үйлчилгээний дугаарт Хавсралт №1-ийн 1.6-д заасан нөхцөлийн дагуу шилжүүлэх боломжтой.

#### ТАВ. ЭЗЭМШИХ ЭРХ ШИЛЖҮҮЛЭХ

- 5.1 Эзэмших эрх шилжүүлэх тохиолдолд эзэмших эрх шилжүүлэгч болон эзэмших эрх хүлээн авагч тус тус өөрийн биеэр үйлчилгээний салбарт хандана.
- 5.2 Сар бүрийн 06-ны өдрөөс эхлэн Эзэмших эрх шилжүүлэх боломжтой бөгөөд эзэмших эрх шилжүүлэгч нь тухайн өдрийг хүртэл гарсан нийт төлбөр тооцоог бүрэн барагдуулна.
- 5.3 Эзэмших эрх шилжүүлсэн тохиолдолд хүлээн авсан хэрэглэгчтэй МОНГОЛДОО дараа төлбөрт үйлчилгээний гэрээг байгуулна.
- 5.4 Эзэмших эрх хүлээн авагч нь тухайн дугаарыг сарын хэдний өдөр хүлээн авснаас үл хамааран багцын сарын суурь хураамж бүтэн нэхэмжлэгдэнэ.
- 5.5 Эзэмших эрх шилжих үед тухайн дугаарын ярианы хэрэглээ, багцад дагалдах дата, нэмэлтээр идэвхжүүлсэн дата багц болон задгай датаны эрхүүд шинэчлэгдэнэ.
- 5.6 Дараах хүндэтгэх шалтгаанаар эзэмших эрхийг нэг талын хүсэлтээр шилжүүлэх боломжтой. Үүнд:
  - 5.6.1 Эзэмшигч нас барсан тохиолдолд эрх хүлээн авагч өөрийн биеэр эзэмшигчийн нас барсны гэрчилгээ, эзэмшигчийн гэр бүлийн гишүүн (гэр бүлийн гишүүн гэдгийг эзэмшигчийн эхнэр, нөхөр, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, насанд хүрсэн төрсөн, дагавар болон үрчилж авсан хүүхэд, төрсөн ах, эгч, дүүг ойлгоно) болохыг нотолсон лавлагааны хамт үйлчилгээний салбарт ирнэ.
  - 5.6.2 Эзэмшигч гадаад улсад ажиллаж, амьдарч байгаа тохиолдолд эзэмшигчийн тухайн улсад оршин сууж буйг нотолсон баримт бичиг, гадаад паспорт болон цахим үнэмлэхний хуулбар, эзэмших эрхээ шилжүүлэхийг зөвшөөрсөн тухай баталгаат гарын үсэгтэй өргөдлийг өөрийн и-мэйл хаягаар илгээх боломжтой ба эрх хүлээн авагч нь цахим үнэмлэхний хамт өөрийн биеэр үйлчилгээний салбарт ирнэ.

#### ЗУРГАА. ОЛОН УЛСЫН РОУМИНГ ҮЙЛЧИЛГЭЭ

##### 6.1 Мессэж роуминг үйлчилгээ

- 6.1.1 Мессэж роуминг үйлчилгээг дараа төлбөрт үйлчилгээний хэрэглэгч нэмэлт барьцаа төлбөр байршуулахгүйгээр ашиглах боломжтой бөгөөд мессэж хүлээн авахад үнэ төлбөргүй, илгээхэд тухайн зорчсон бүс нутаг болон орнуудаас шалтгаалан харилцан адилгүй байна.
- 6.1.2 Мессэж роуминг үйлчилгээ нь дараа төлбөрт үйлчилгээний шинэ хэрэглэгч болох үед идэвхжих ба гадаад улс рүү зорчихдоо тусгай дугаарт мессэж илгээн идэвхжүүлэх шаардлагагүйгээр шууд ашиглах боломжтой байна.
- 6.1.3 Хэрэглэгч тусгай дугаарт мессэж илгээн мессэж роуминг үйлчилгээг хаах мөн буцаан идэвхжүүлэх боломжтой. Үүнд:
  - 6.1.3.1 Мессэж роуминг үйлчилгээг цуцлах бол 599 дугаарт “Off” утга илгээнэ.
  - 6.1.3.2 Мессэж роуминг үйлчилгээг идэвхжүүлэх бол 599 дугаарт “sms” утга илгээнэ.

##### 6.2 Яриа болон мессэж роуминг үйлчилгээ

- 6.2.1 Дараа төлбөрт хэрэглэгч Яриа-мессэж роуминг үйлчилгээний эрх нээлгэхдээ үйлчилгээний салбарт хандан, Хавсралт №2-ын 2.3-т заасан барьцаа төлбөрийг байршуулна.
- 6.2.2 Хэрэглэгч 12 сар болон түүнээс дээш хугацаанд дугаараа идэвхтэй ашигласан тохиолдолд Яриа-мессэж роуминг үйлчилгээг Олон Улсын Роумингийн барьцаа байршуулахгүй ашиглана.

6.2.3 Яриа-мессэж роуминг үйлчилгээг 6.2.1 болон 6.2.2-т заасан хэрэглэгч 599 дугаарт “call” гэсэн мессэжийг илгээн идэвхжүүлэх боломжтой.

##### 6.3 Цогц роуминг үйлчилгээ

- 6.3.1 Цогц роуминг үйлчилгээг зөвхөн дараа төлбөрт үйлчилгээний 3G болон 4G LTE сүлжээний хэрэглэгч Хавсралт №2-ын 2.3-т заасан барьцаа төлбөрийг байршуулан Олон улсын Роуминг үйлчилгээний Гэрээ байгуулан ашиглах боломжтой бөгөөд дараах үйлчилгээг ашиглана. Үүнд:
  - 6.3.1.1 Дуудлага хийх, хүлээн авах;
  - 6.3.1.2 Мессэж илгээх, хүлээн авах;
  - 6.3.1.3 Дата /интернет үйлчилгээ/ ашиглах;
- 6.3.2 Хэрэглэгч цогц роуминг үйлчилгээний эрхийг салбарт хандан Хавсралт №1-ийн 1.4-т заасан бичиг баримтад үндэслэн идэвхжүүлнэ.

##### 6.4 Дата роуминг багц

- 6.4.1 Дата роуминг багцын үйлчилгээг Олон улсын Роуминг үйлчилгээ идэвхжүүлсэн хэрэглэгч авах боломжтой ба дата роумингийн үндсэн багцуудыг 599 тусгай дугаарт мессэж илгээн идэвхжүүлэн ашиглана.
- 6.4.2 Дата роуминг багцын харгалзах эрхээс хэтэрсэн дата хэрэглээг Олон улсын Роуминг үйлчилгээний задгай датаны хэрэглээний тарифаар тооцон нэхэмжилнэ.
- 6.4.3 Дата роуминг багцуудыг давхар идэвхжүүлсэн тохиолдолд багцууд зэрэг идэвхжих бөгөөд хэрэглэгчийн аль улсад байгаагаас хамаарч харгалзах улсын багцаас хэрэглээг тооцно.
- 6.4.4 Дата роуминг багцын хэрэглээ болон дуусах хугацааг шалгахдаа 599 тусгай дугаарт “data” утга илгээнэ.
- 6.5 Хэрэглэгч Олон Улсын Роуминг үйлчилгээг ашиглахдаа дараах зүйлийг анхаарна. Үүнд:
  - 6.5.1 Хэрэглэгч зорчих улсынхаа үүрэн операторын Олон Улсын Роуминг үйлчилгээний яриа, мессэж, дата үйлчилгээний тарифтай урьдчилан танилцсан байна. ([www.skytel.mn](http://www.skytel.mn) – Бүтээгдэхүүн үйлчилгээ – ОУ-ын үйлчилгээ – Роуминг үйлчилгээ, 1515 лавлах төв)
  - 6.5.2 Олон Улсын Роуминг үйлчилгээний тарифын мэдээллийг 599 тусгай дугаарт тухайн улсын Олон Улсын нэрний эхний 4 үсгийг /Латин үсэг/ мессэжээр илгээн авах боломжтой.
  - 6.5.3 Хэрэглэгч 1510 тусгай дугаарт “R” үсгийг илгээн Олон Улсын Роуминг үйлчилгээний хэрэглээгээ шалгана.
  - 6.5.4 Өөр операторын сүлжээнд байхдаа хэрэглээ шалгах тариф нь тухайн орны Олон улсын Роуминг үйлчилгээний мессэж илгээх тарифаар тооцогдоно.
  - 6.5.5 Хэрэглэгч хэрэглээгээ тогтмол хянаж, гарсан төлбөр тооцоог бүрэн хариуцна.
  - 6.5.6 Олон Улсын яриа үйлчилгээний барьцаа болон Олон Улсын Роуминг үйлчилгээнд байршуулсан барьцаа дүнгээс хамааран дотоод, гадаад хэрэглээ Хавсралт №2-ын 2.3-т заасан нөхцөлөөр хязгаарлагдана.

#### ДОЛОО. ТӨЛБӨР ТООЦОО

##### 7.1 Ярианы минутын алхам тооцоолол

- 7.1.1 Монгол Улс доторх яриаг 1 (нэг) минутын алхмаар тооцох бөгөөд нэг минут хүрээгүй яриаг нэг бүхэл минутаар тооцно.
- 7.1.2 Олон улсын яриа нь эхний бүрэн ба бүрэн бус 6 (зургаан) секунд хүртэлх яриаг 6 секундээр, 7дахь секундээс 1 секундийн алхмаар тооцогдох бөгөөд холбогдож буй улсаас хамаарч нэг минутын ярианы тариф харилцан адилгүй байна.

##### 7.2 Хэрэглээний мэдээлэл

- 7.2.1 Хэрэглэгч сар бүрийн 06-ны өдрөөс хойш 1510 тусгай дугаарт В үсгийг илгээж хэрэглээний төлбөрийг, U үсгийг илгээж хэрэглээний мэдээллийг, D үсгийг илгээж дата хэрэглээний мэдээллийг тус тус мессэж хэлбэрээр авах боломжтой.
- 7.2.2 Хэрэглээний дэлгэрэнгүй жагсаалт нь тухайн дугаарын сүүлийн 3 сарын зөвхөн гарах яриа, мессэж, дата хэрэглээ, тэдгээрт бодогдсон төлбөр тооцооны жагсаалт хэлбэртэй байх бөгөөд захидал харилцааны аливаа агуулгагүй байна.

##### 7.3 Төлбөр төлөх боломж

- 7.3.1 Хэрэглэгч ашигласан хэрэглээний төлбөрийг сар бүрийн 20-ны дотор доорх сувгуудаас сонгон төлөх боломжтой. Үүнд:
  - 7.3.1.1 Үйлчилгээний салбар;
  - 7.3.1.2 [www.skytel.mn](http://www.skytel.mn), Skytel болон банкны аппликэйшн;
  - 7.3.1.3 Киоск төхөөрөмж;
  - 7.3.1.4 Чат бот;
  - 7.3.1.5 Сервис дилер;
  - 7.3.1.6 Худалдаа хөгжлийн банк болон Хаан банкны АТМ-ээр;
  - 7.3.1.7 Дараа төлбөрт үйлчилгээний нөхцлийн Хавсралт №2-ын 2.5-д заасан банкны автомат данс;

#### НАЙМ. ҮЙЛЧИЛГЭЭГ ЗОГСОХ

- 8.1 Тухайн сарын хэрэглээний төлбөрийг дараа сарын 20-ны дотор төлөөгүй тохиолдолд сарын сүүлийн өдөр хүртэл гарах яриа, мессэж, датаүйлчилгээний эрхийг хязгаарлаж, орох үйлчилгээний эрхийг хэвээр

үлдээх бөгөөд сарын сүүлийн өдөр орох, гарах үйлчилгээний эрхийг төлбөр төлөх өдөр хүртэл хязгаарлана.

- 8.2 Багцаас хэтэрсэн яриа, мессэж, дата хэрэглээний төлбөр хэрэглээний хязгаарлалтын дүнд хүрсэн тохиолдолд гарах үйлчилгээний эрхийг төлбөр төлөх өдөр хүртэл зогсоох ба орох үйлчилгээний эрх нээлттэй байна.

#### ЕС. ГЭРЭЭ ЦУЦЛАХ

9.1 Талууд дараах үндэслэлээр энэхүү гэрээг цуцалж болно. Үүнд:

9.1.1 Гэрээнд заасан аль нэг үүргээ биелүүлээгүй бол;

9.1.2 Хэрэглэгчийн эрх зүйн чадвар дуусгавар болсноор;

9.1.3 Хэрэглэгчийн хүсэлтээр;

9.1.4 Хуульд заасан бусад үндэслэлээр;

9.2 Хэрэглэгч гэрээг цуцлах тухай саналыг Үйлчилгээ үзүүлэгчид ажлын 3 хоногийн өмнө мэдэгдэж үйлчилгээг хаалгана.

9.3 Хэрэглэгч өөрийн хүсэлтээр гэрээг цуцлах үед үйлчилгээний төвд өөрийн биеэр цахим үнэмлэхний мэдээлэл болон тоон гарын үсэг зурсан тохиолдолд дараах төлбөрүүдийг төлж барагдуулан үйлчилгээг зогсооно. Үүнд;

9.3.1 Гэрээг цуцлах хүртэлх хугацаанд ашигласан үйлчилгээний нийт төлбөр;

9.3.2 Бусад төлбөр, зардлууд;

9.4 Хэрэглэгч гэрээ цуцлах хүсэлтээ албан ёсоор мэдэгдээгүй болон дугаар хадгалуулах үйлчилгээ аваагүй тохиолдолд тухайн дугаарыг идэвхгүй төлөвт шилжсэнээс хойш 91 дэх хоногт барьцаа төлбөрөөс хэрэглээний нийт төлбөрийг суутгах ба барьцаа төлбөрөөс хэтэрсэн үлдэгдэл төлбөрийг хэрэглэгч бүрэн хариуцан барагдуулна.

#### АРАВ. БУСАД

10.1 Энэхүү дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлд шууд заагаагүй, тусгагдаагүй бусад үйлчилгээний нөхцөлийг тухайн үед Скайтел ХХК-ийн Хэрэглэгчид үзүүлж буй үйлчилгээний нөхцөлөөр зохицуулагдах ба Дараа төлбөрт үйлчилгээний нөхцөлд Скайтел ХХК дангаараа өөрчлөлт оруулах эрхтэй.

1.1 Энгийн, азын, мөнгөн ,алтан дугаар		
Дугаарын төрөл		Бүртгэлийн хураамж
Энгийн	ABCD	0₮
Азын	ABBA, AAAB, BAAA	100,000₮
Мөнгөн	AABB, ABAB,	300,000₮
Алтан	AAAA	1,000,000₮
	хBAA-хBAA	
	ххAB-ABAB	

1.1.1 Үнэ цэнтэй дугаар			
Дугаарын төрөл		Бүртгэлийн хураамж	
9111**** 9191**** 9000**** 9090**** 6969**** 6999****	Энгийн	100,000₮	
	Азын	ABBA, AAAB, BAAA	300,000₮
	Мөнгөн	AABB, ABAB	1,000,000₮
	Алтан	х*AA-AAAA	3,000,000₮
		хBAA-хBAA	
		ххAB-ABAB	

1.2 Шинэ хэрэглэгчийн суурь хураамж тооцох	
Шинэ хэрэглэгч болсон өдөр	Сарын суурь хураамж тооцох хувь
1-10-ны өдрүүдэд	100%
11-20-ны өдрүүдэд	50%
21-31-ний өдрүүдэд	30%

1.3 Хэрэглээ хийгээгүй үеийн суурь хураамж	
Багцын төрөл	Суурь хураамж
МОНГОЛдоо 10	5,000₮
МОНГОЛдоо 20	10,000₮
МОНГОЛдоо 30	15,000₮
МОНГОЛдоо 40	20,000₮
МОНГОЛдоо 55	27,500₮
МОНГОЛдоо 70	35,000₮
МОНГОЛдоо 100	50,000₮

1.4 ОУ-ын үйлчилгээ идэвхжүүлэхэд шаардлагатай бичиг баримт	
Хувь хэрэглэгч	Иргэний үнэмлэх эсвэл тоон гарын үсэг зурах

1.5 Задгай дата хэрэглээг гигабайт (GB)-н нэгжээр тооцох				
Багц	Дата тариф			
	Хэрэглээ	1GB дата тариф	Хэрэглээ	1GB дата тариф
МОНГОЛдоо 20	0.1GB-10GB хүртэл	3,000₮	10GB- с дээш	1,500₮
МОНГОЛдоо 30				
МОНГОЛдоо 40		2,000₮		1,000₮
МОНГОЛдоо 55				
МОНГОЛдоо 70				
МОНГОЛдоо 100				

1.6 Дата хуваалцах үйлчилгээ	
Хуваалцах дата	Дата хуваалцах үйлчилгээний төлбөр
1GB	500₮
2GB	1000₮
3GB	1500₮
4GB	2000₮
6GB	3000₮

- Админ дугаар дагалдах датанаас хуваалцах боломжтой, дата шилжүүлж авч байгаа дугаар сард 3 удаа авах боломжтой, хүлээн авсан дата сарын сүүлийн өдөр устана.

2.1 Багцын үнэ						
Багц	МОНГОЛДОО					
	20	30	40	55	70	100
Багцын сарын суурь хураамж	20,000₮	30,000₮	40,000₮	55,000₮	70,000₮	100,000₮
Багцын дагалдах дата	6GB	30GB	50GB	80GB	100GB	150GB
Нэмэлт үйлчилгээ	-			GO+ Basic plus багц , ОУ-ын дата eSim 20000₮ эрх, eSim сэргээлт		
Дата хуваалцах /хэмжээ, үнэ/	-	10GB- 5000₮		20GB-0₮		
Үндсэн барьцаа	0₮					

2.2 Яриа, мессеж, задгай дата хэрэглээний тариф				
Багц	Задгай яриа	Задгай мессеж	1GB дата тариф	
			10GB хүртэл	10GB дээш
МОНГОЛдоо 20	50₮	20₮	3000₮	1500₮
МОНГОЛдоо 30				
МОНГОЛдоо 40			2000₮	1000₮
МОНГОЛдоо 55				
МОНГОЛдоо 70				
МОНГОЛдоо 100				

2.3 Олон Улсын үйлчилгээ	Барьцаа төлбөр	Хэрэглээ хязгаарлах
Олон Улсын ярианы үйлчилгээ	100,000₮	100,000₮
	200,000₮	200,000₮
Яриа-мессеж хосолсон роуминг	*	200,000₮
	100,000₮	200,000₮
Цогц роуминг	350,000₮	500,000₮
	500,000₮	Хязгааргүй

2.4 Захиалгат үйлчилгээний төлбөр	
	Төлбөргүй
Багц хооронд шилжих /Буурах, ахих/	
Дугаарын сүүлийн 4 орон солих	20,000₮
Дугаар хадгалах	1 удаа 1-4 сар хүртэлх хугацаанд үнэгүй дахин 1-12 сар хадгалах бол сар бүр 10,000₮
Сим карт сэргээх	3,000₮
eSIM бүртгэлийн хураамж	5,000₮
eSIM QR код дахин авах	5,000₮
Үйлчилгээ хооронд шилжих/УТУ-с ДТУ-рүү, ДТУ-с буцаж УТУ-рүү /	Төлбөргүй
Онлайн яриа болон мессеж	300₮

2.5 Дансны мэдээлэл		
Банкны нэр	IBAN	Дансны дугаар
ХХБ банк	MN56 0004 000	499 120 987
Хас банк	MN71 0032 00	500 167 8218
Хаан банк	MN85 0005 00	503 801 9105
Голомт банк	MN77 0015 00	110 204 6354
Төрийн банк	MN52 0034	106 000 002 843